



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 23 өдөр

Дугаар A/347

Номгон

Сумдын багийн Засаг дарга нарт мотоцикл  
хүлээлгэн өгөх ажлын хэсэг байгуулах  
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5 дахь заалт, аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 6/23 дугаар тогтоолоор баталсан аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөөний 7 дугаар зүйлийн 7.1.11 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баянхонгор аймгийн 19 сумын багийн Засаг дарга нарт олгогдох мотоциклийг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:

П.Отгонбаяр Төрийн захиргааны, удирдлагын хэлтсийн дарга

Гишүүд:

Б.Мөнхзаяа Үйлчилгээний нэгдсэн төвийн менежер

Н.Жаргалмаа Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн

Э.Долгорсүрэн Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:

М.Янжмаа Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн


2. Тээврийн хэрэгслийг 2023 оны 06 дугаар сарын 25-ны дотор хүлээн авч байгууллагын өмчид бүртгэж авахыг Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн (Э.Долгорсүрэн)-д хариуцуулсугай.

3. Мотоцикуудыг техникийн тодорхойлолтой тулган хүлээн авч багийн Засаг дарга нарт хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулж тайланг 06 дугаар сарын 30-ны дотор танилцуулахыг ажлын хэсэг (П.Отгонбаяр)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхжаргал)-д даалгасугай.

ДАРГА

Д.МӨНХСАЙХАН



643310887